

## БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад одоо бэлчээрийн харилцааг дараах хуулиудаар зохицуулж байна. Үүнд:

- **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС ...**

**Зургадугаар зүйл:**

1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.

Энэхүү хуулийн 6.2 дахь заалтаар бэлчээрийг төрийн өмч мөн болохыг баталгаажуулсан бөгөөд 6.3 дахь заалтаар бэлчээрийг өмчлүүлэх асуудлыг хориглосон байна.

№	Хуулийн холбогдох зүйл, заалтын агуулга:
1.	<p style="text-align: center;"><b>ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2002-06-07.</p> <p><b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</b></p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.6. “<b>бэлчээр</b>” гэж мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газарт хамааруулсан газрыг;</p> <p><b>5 дугаар зүйл. Газар өмчлөгч</b></p> <p>5.1. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн.</p> <p>5.2. <b>Бэлчээр</b>, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.</p> <p><b>6 дугаар зүйл. Газар эзэмшигч, ашиглагч</b></p> <p>6.1. Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана.</p> <p>6.2. Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь газрыг төрийн зохих шатны байгууллагын хяналт, зохицуулалттайгаар нийтээр ашиглана:</p> <p>6.2.1. <b>бэлчээр</b>, <b>бэлчээр</b> дэх уст цэг, хужир мараа бүхий газар;</p>

### **11 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн газар**

11.1. Хөдөө аж ахуйн газарт **бэлчээр**, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.

### **16 дугаар зүйл. Тусгай хэрэгцээний газар**

16.1. Монгол Улс тусгай хэрэгцээний газартай байна. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

16.1.6. аймаг дундын отрын **бэлчээр**;

### **50 дугаар зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг шаардлага**

50.1.1. газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;

### **52 дугаар зүйл. **Бэлчээр**, түүнийг зохистой ашиглах, хамгаалах**

52.1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутгийн онцлог, **бэлчээр**ийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батална.

52.2. Зуслан, намаржаа болон отрын **бэлчээр**ийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн **бэлчээр**ийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны **бэлчээр**ийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг **бэлчээр**ийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, **бэлчээр** ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.

52.3. Ойн сан бүхий газрыг зохих хууль тогтоомжийн дагуу **бэлчээр**т ашиглаж болно.

52.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ **бэлчээр**ийн болон суурин мал маллагааны бүс нутгийг тогтоож болно.

52.5. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор хашсан **бэлчээр**ийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад улирал харгалзахгүй тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

52.6. Энэ хуулийн 52.1-д заасан ерөнхий хуваарь, 52.4, 52.5-д заасан газрын хэмжээ болон уг газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

52.7. Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот

	<p>айлаар дундаа хамтран эзэмшиж болно.</p> <p>52.8. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарвал тухайн шатны Засаг дарга нар уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга буюу Засгийн газар шийдвэрлэнэ.</p> <p><i>/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>52.9. Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед ашиглах сум дундын отрын нөөц нутаг, түүний заагийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг дундын отрын нөөц нутаг, түүний заагийг орон нутгийн удирдлагын хүсэлтийг харгалзан Засгийн газар тогтооно.</p> <p><i>/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>52.10. <b>Бэлчээр</b> ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.</p> <p><b>53 дугаар зүйл. Хадлангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах</b></p> <p>53.3.Газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хориглоно.</p> <p>53.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон <b>бэлчээр</b> ийн зохих ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно. Энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй.</p> <p><b>58 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах</b></p> <p>58.2. Тариалангийн газраас бусад ангиллын газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг дараахь үзүүлэлтээр гаргана:</p> <p>58.2.6. <b>бэлчээр</b>, хадлангийн талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүний өөрчлөлт.</p>
2.	<p style="text-align: center;"><b>ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2011 оны 12 сарын 23 өдөр.</p> <p><b>58 дугаар зүйл.Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг:</b></p> <p>58.4.5.сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бэлчээрийн менежмент хийх;</p> <p>58.4.6.сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах;</p>
3.	<p style="text-align: center;"><b>БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>1995-04-11.</p> <p><b>14 дүгээр зүйл.Бэлчээр, хадлангийн ургамлыг мал тэжээх</b></p>

	<p><b>зориулалтаар ашиглах</b></p> <p>1. <b>Бэлчээр</b>ийн мал аж ахуйн эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа /оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр <b>бэлчээр</b>, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуулийн 52, 53 дугаар зүйлийг баримтална.</p> <p><i>/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн 2 хүртэл жилийн хугацаагаар хориглож болно.</p> <p><i>/Энэ хэсэгт 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/</i></p> <p>3. Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор <b>бэлчээр</b>, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга шийдвэрлэнэ.</p>
4.	<p align="center"><b>БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>1995-3-30.</p> <p><b>18 дугаар зүйл. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх</b></p> <p>1. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлан, <b>бэлчээр</b>, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах;</p> <p><b>20 дугаар зүйл. Байгаль орчны чадавхийн хэм хэмжээ</b></p> <p>1. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчинд гаргах хортой, аюултай бодисын агууламж, үзүүлэх сөрөг нөлөөллийн түвшний хэм хэмжээ / цаашид "байгаль орчны чадавхийн хэм хэмжээ" гэх/ -г дараахь үзүүлэлтээр тогтооно:</p> <p>5/газар тариалан, <b>бэлчээр</b> хамгаалахад хэрэглэх агрохимийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;</p>
5	<p align="center"><b>БҮСЧИЛСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2003 оны-5-30.</p> <p><b>8 дугаар зүйл. Зөвлөлийн бүрэн эрх</b></p> <p>8.1. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.9. бүсийн тэжээл тариалах, хадлан хадах талбай болон <b>бэлчээр</b> нутгийг тодорхойлох, байгалийн гамшгаас мал сүргийг урьдчилан сэргийлэх, хамгаалах бүс нутгийн сүлжээ бүрдүүлэх;</p>
6.	<p align="center"><b>ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p>

1997 оны 4-24.

**6 дугаар зүйл. Газрын төлбөр тооцох үзүүлэлт, тэдгээрийг тодорхойлох**

1.Газрын төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжийг дараахь байдлаар тооцож тодорхойлно:

1/ **бэлчээр**ийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрийг уг **бэлчээр**ийн нэгж талбайн суурь үнэлгээний хувиар хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд;

2/ Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зам, шугам сүлжээний газрын километр тутмаас;

3/ энэ хэсгийн 1, 2-т зааснаас бусад газрын төлбөрийг нэг га газрын суурь үнэлгээний хувиар.

2. **Бэлчээр**ийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа өмнөх жилийн эцэст тоологдсон адууг 6,0, үхрийг 6,0, тэмээг 5,0, ямааг 0,9 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно.

**7 дугаар зүйл. Газрын төлбөрийн хувь, хэмжээ**

1. Газрын төлбөрийг түүний суурь үнэлгээнээс энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр дараахь хязгаарт багтаан хувь, хэмжээгээр тогтооно:

1/ нэг хонин толгойд ногдуулах **бэлчээр**ийн газрын төлбөрийн хязгаар 0,01-0,03 хувь;

**8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх**

1. Дараахь төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө:

1/ малчин өрхийг **бэлчээр**, хадлангийн газрын;

6/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хөрсний бүтцийг

сайжруулах, **бэлчээр**т шилжүүлэх зорилгоор олон наст болон буурцагт

ургамал тариалсан талбайг эзэмшиж, ашигласны төлбөрөөс эхний 5 жил

хүртэлх хугацаанд;

7.

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС**

2017-05-11.

**7.7 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль зөрчих**

1.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

2.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, **бэлчээр**, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**8.1 дүгээр зүйл.Газрын тухай хууль зөрчих**

6.**Бэлчээр**ийг зохистой ашиглах, эсхүл хамгаалах журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

	<p><b>13.1 дүгээр зүйл.Тариалангийн тухай хууль зөрчих</b></p> <p>6.Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд:</p> <p>6.1.мал бэлчээсэн;</p> <p>6.2.оторлосон;</p> <p>6.3.<b>бэлчээр</b>ийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байлгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
8.	<p><b>КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>1999-12-16.</p> <p><b>5 дугаар зүйл.Кадастрын зураглалын солбицлын тогтолцоо, масштаб, нарийвчлал</b></p> <p>5.3.Кадастрын зургийг тухайн кадастрын үндсэн болон дэд ангиллаас нь хамааруулан дараахь масштабаар тус тус үйлдэнэ:</p> <p>5.3.1.энэ хуулийн 4.1.2; 4.1.3 -т заасан төрлийн кадастрын зургийг 1:2000-аас багагүй масштабаар;</p> <p>5.3.2.жимс жимсгэнэ, ногооны талбайн кадастрын зургийг 1:2000-аас, тариалангийн талбайд 1:25000-аас, хадлангийн талбайд 1:50000-аас, <b>бэлчээр</b>, ой, усан сан, геологи, уул уурхайн талбайд 1:100000-аас тус тус багагүй масштабаар.</p>
9.	<p><b>МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2002-06-27.</p> <p><b>6 дугаар зүйл. Иргэнд өмчлүүлэх газар</b></p> <p>6.1. Иргэнд газар тариалангийнхаас бусад зориулалтаар дараахь газрыг өмчлүүлнэ:</p> <p>6.1.1. хот, тосгон, бусад суурины нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэрийн газар /гудамж, талбай, зам, амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэг, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг/, <b>бэлчээр</b>, ойн болон усны сан бүхий газар, тусгай хэрэгцээний газар, зам, шугам сүлжээний газраас бусад газарт;</p>
10.	<p><b>ОЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр.</p> <p><b>4.4.Ойн нөөц болон ойн санг дор дурдсанаар эзэмшүүлнэ:</b></p> <p>4.4.2.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад.</p> <p><b>30 дугаар зүйл.Ойг нөхөн сэргээх, үржүүлэх</b></p> <p>30.3.Тал хээр, говь, цөлийн бүсийг ойжуулах, гол, горхи, булаг, шандын эх, <b>бэлчээр</b>, тариалангийн талбайг хамгаалах зорилгоор ногоон зурвас байгуулах хөтөлбөр, төслийг улсын төсөв, бусад эх үүсвэрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.</p>

11.	<p style="text-align: center;"><b>ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p style="text-align: center;">2016-1-29</p> <p><b>7 дугаар зүйл. Тариалсан газар</b></p> <p>7.1.Тариалсан газарт хүний үйл ажиллагаагаар тарьж ургуулсан таримал ургамал бүхий талбай хамаарна.</p> <p>7.2.Доор дурдсан таримал ургамал бүхий талбайг тариалсан газарт хамааруулахгүй:</p> <p>7.2.1.үр цацах, услах, бордох зэргээр сайжруулж тордсон <b>бэлчээр</b>, хадлангийн талбай;</p> <p><b>17 дугаар зүйл. Тариалангийн бүс нутаг</b></p> <p>17.1.Тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх зорилгоор тариалангийн бүс нутгийг энэ хуульд заасны дагуу тогтоож болно.</p> <p>17.5.Тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан <b>бэлчээр</b>т эрхэлнэ.</p> <p><b>24 дүгээр зүйл. Тариалангийн үйлдвэрлэлийг хамгаалах</b></p> <p>4.1.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>24.1.1.мал, тэжээвэр амьтан оруулах, бэлчээх;</p> <p>24.2.Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон <b>бэлчээр</b>ийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно.</p> <p>24.3.Энэ хуулийн 24.2-т заасан мал аж ахуй эрхлэгчийн өвөлжөө, хаваржааг тухайн орон нутагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон тээврийн зардлыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч нэг удаа хариуцна.</p> <p>24.4.Энэ хуулийн 24.3-т заасны дагуу нүүн шилжих мал аж ахуй эрхлэгчийн өвөлжөө, хаваржааны газрын асуудлыг сум, дүүргийн Засаг дарга 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.</p> <p>24.5.Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн, хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.</p>
12.	<p style="text-align: center;"><b>ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>1997-10-23.</p> <p><b>4 дүгээр зүйл.Орчны бүсийг тогтоох шалгуур</b></p> <p>4.1.Дараахь шалгуурыг харгалзан орчны бүсийг тогтооно:</p> <p>4.1.2.в. нутгийн хүн ам, айл өрх, малын нягтрал нь <b>бэлчээр</b>ийн даац, усны хангамжийн хүрэлцээнд сөрөг нөлөө үзүүлж байгаа газар нутаг;</p>

13.	<p style="text-align: center;"><b>ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>1994-11-15.</p> <p><b>12 дугаар зүйл. Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа</b></p> <p>Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал <b>бэлчээр</b>лүүлэх;</p> <p><b>37 дугаар зүйл. Газар ашиглах тухай гэрээ</b></p> <p>1. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна.</p> <p>2. Газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:</p> <p style="padding-left: 40px;">/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/</p> <p style="padding-left: 40px;">1/ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;</p> <p style="padding-left: 40px;">2/ газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;</p> <p style="padding-left: 40px;">3/ газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;</p> <p style="padding-left: 40px;">4/ гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.</p>
14.	<p style="text-align: center;"><b>УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2007-11-15.</p> <p><b>1 дүгээр зүйл. Хуулийн зорилт</b></p> <p>1.1. Энэ хуулийн зорилт нь <b>бэлчээр</b>ийн болон таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлаас хамгаалах, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p><b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо</b></p> <p>3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.1. <b>“бэлчээр”</b> гэдгийг Газрын тухай хуулийн 3.1.6-д зааснаар ойлгоно;</p> <p>3.1.3. “ургамал хамгаалал” гэж <b>бэлчээр</b>ийн болон таримал ургамал</p>



	<p>/цаашид “ургамал” гэх/-ыг ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, хорио цээр тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх цогц үйл ажиллагааг;</p> <p><b>5 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага</b></p> <p>5.2. Төв байгууллага нь <b>бэлчээр</b>ийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ байна.</p> <p><b>7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх</b></p> <p>7.1. Засгийн газар ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.2. <b>бэлчээр</b>ийн болон таримал ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоох, цуцлах;</p> <p><b>8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b></p> <p>8.1. Төрийн захиргааны төв байгууллага ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>8.1.9. <b>бэлчээр</b>ийн ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалт, олшролтын тодотгох судалгааг салбарын эрдэм шинжилгээний байгууллагаар хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;</p> <p><b>10 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх</b></p> <p>10.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ургамал хамгааллын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.8. <b>бэлчээр</b>, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зөрчлийг арилгуулах.</p> <p><b>16 дугаар зүйл. Ургамал хамгааллын үйл ажиллагааны санхүүжилт</b></p> <p>16.2. Ургамал хамгааллын үйл ажиллагааны дараахь зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:</p> <p>16.2.2. <b>бэлчээр</b>ийн ургамалд ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан тархаж, хөнөөл учруулах үед түүнтэй тэмцэх зардал;</p>
15.	<p><b>ХӨРС ХАМГААЛАХ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИАС</b></p> <p>2012-05-17.</p> <p><b>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b></p>

	<p>4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.2.“хөрсний доройтол” гэж хөрсний үржил шим муудах, элэгдэл, эвдрэлд орох, бохирдох, <b>бэлчээр</b> талхлагдаж анхны шинж чанараа алдахыг;</p> <p><b>7 дугаар зүйл.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ</b></p> <p>7.1.Хөдөө аж ахуйн газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.4.<b>бэлчээр</b>ийг тухайн орон нутгийн малын тоо толгойд тохируулан улирлын хуваарьтай ашиглах.</p> <p>7.3.Тусгай хэрэгцээний газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:</p> <p>7.3.2.аймаг дундын отрын <b>бэлчээр</b>ийн болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн газрыг хуваарьтай сэлгэн ашиглах;</p> <p><b>10 дугаар зүйл.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх үйл ажиллагааг урамшуулах</b></p> <p>10.1.Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан урамшууллыг дараах тохиолдолд олгоно:</p> <p>10.1.6.<b>бэлчээр</b>ийг улирлын хуваарьтай сэлгэн ашигласан.</p>
16.	<p align="center"><b>БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ЧИГЛЭЛ</b></p> <p>УИХ-ын 2016-09-09.</p> <p><b>45 дугаар тогтоол:</b> “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”</p> <p>Мал аж ахуй чиглэлээр дараах асуудалд анхаарч ажиллана: бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулна, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор <b>Бэлчээр хамгаалах тухай хууль боловсруулж батлуулна.</b></p>
17.	<p>УИХ-ын 2016-02-05.</p> <p><b>19 дүгээр тогтоол:</b></p> <p>“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай”</p> <p>Бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо,төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх,эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх.</p>

18.	<p>УИХ-ын 2001 оны <b>57 дугаар тогтоолоор</b> баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”</p> <p>2.2. Эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд байгаль орчиндоо зохицсон бэлчээрийн мал аж ахуйн орон зайн зохион байгуулалтын дэвшилттэй бүхнийг орчин үеийн суурин соёл иргэншлийн ололттой зүй зохистой хослуулах зарчмыг баримтална.</p> <p>4.5. Бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан баруун бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, усалгаатай тариалан, жижиг, дунд боловсруулах үйлдвэрийг; хангайн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг; төвийн бүсэд: бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ</p>
-----	--